

**7 дугаар бүлэгт дурдсан
5 дугаар хавсралт**

Цахилгаан холбооны үйлчилгээ

**1 дүгээр зүйл
Хамрах хүрээ**

1. Энэхүү хавсралт нь цахилгаан холбооны үйлчилгээний худалдаанд нөлөө үзүүлэхүйц арга хэмжээнд хамаарна.

2. Энэхүү хавсралт нь Тал бүрийн хууль тогтоомжид заасан телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээнд нөлөө үзүүлэхүйц арга хэмжээнд үйлчлэхгүй.

3. Энэхүү хавсралтыг дараахаар тайлбарлахгүй:

- (a) аль нэг Тал 6 дугаар хавсралтад дурдсан Тусгай үүрэг амлалтын жагсаалтаас бусад цахилгаан холбооны дамжуулах сүлжээ, эсхүл үйлчилгээг үүсгэх, байгуулах, худалдан авах, түрээслэх, ажиллуулах буюу үзүүлэх зөвшөөрлийг нөгөө Талын үйлчилгээ үзүүлэгчид олгохыг шаардах;
- (b) аль нэг Талыг нийтийн хэрэглээний бус зориулалтаар цахилгаан холбооны сүлжээ болон үйлчилгээг үүсгэх, байгуулах, худалдан авах, түрээслэх, ажиллуулах, эсхүл үзүүлэхийг шаардах (эсхүл тухайн Талын хуулийн харьяалалын хүрээнд үйлчилгээ үзүүлэгчийг үүрэг хүлээхийг шаардах).

**2 дугаар зүйл
Тодорхойлолт**

Энэхүү хавсралтын зорилгоор:

- (a) “өртөгт суурилсан” гэх нэр томъёо нь өртөгт үндэслэхийг хэлэх бөгөөд тэрхүү өртөгт бодит ашгийг тусгах ба ялгаатай байгууламж болон үйлчилгээнд өртөг тооцох өөр аргыг хэрэглэж болно;
- (b) “харилцан татаас олгох” гэх нэр томъёо нь тухайн хуулийн этгээд нэг бүтээгдэхүүн, эсхүл үйлчилгээнээс олсон ашгийг өөрийн бусад бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжихэд ашиглахыг хэлнэ;

- (c) “эцсийн хэрэглэгч” гэх нэр томьёо нь нийтийн цахилгаан холбооны дамжуулах сүлжээ, эсхүл үйлчилгээ үзүүлэгчээс бусад үйлчилгээ үзүүлэгчийг оролцуулан нийтийн цахилгаан холбооны дамжуулах сүлжээ, эсхүл үйлчилгээний эцсийн хэрэглэгч, эсхүл захиалагчийг хэлнэ;
- (d) “үндсэн байгууламж” гэх нэр томьёо нь дараахь нийтийн цахилгаан холбооны дамжуулах сүлжээ, эсхүл үйлчилгээний байгууламжийг хэлнэ:
 - (i) цорын ганц, эсхүл хязгаарлагдмал тооны үйлчилгээ үзүүлэгч дангаар эсхүл давамгайлан хүргэдэг;
 - (ii) тухайн үйлчилгээг үзүүлэхэд эдийн засгийн болон техникийн хувьд орлуулах боломжгүй.
- (e) “харилцан холболт” гэх нэр томьёо нь нэг үйлчилгээ үзүүлэгчийн эцсийн хэрэглэгчийг нөгөө үйлчилгээ үзүүлэгчийн эцсийн хэрэглэгчтэй холбох зорилгоор нийтийн цахилгаан холбооны дамжуулах сүлжээ, эсхүл үйлчилгээг үзүүлж буй үйлчилгээ үзүүлэгчтэй холбох болон нөгөө үйлчилгээ үзүүлэгчийн үзүүлж буй үйлчилгээнд нэвтрэхийг хэлнэ ;
- (f) “голлох үйлчилгээ үзүүлэгч” гэх нэр томьёо нь дараахь байдлаар үндсэн цахилгаан холбооны үйлчилгээний холбогдох зах зээлд үнэ, нийлүүлэлтийн оролцооны нөхцөлд голлон нөлөөлөх боломжтой үйлчилгээ үзүүлэгчийг хэлнэ:
 - (i) үндсэн байгууламжийг хянах;
 - (ii) зах зээл дэх өөрийн байр сууриа ашиглах.
- (g) “үл ялгаварлах” гэх нэр томьёо нь ижил нөхцөлд ижил төрлийн нийтийн хэрэглээний цахилгаан холбооны дамжуулах сүлжээ буюу үйлчилгээг аливаа бусад хэрэглэгчдэд олгож буйгаас дутуугүй тааламжтай нөхцөл олгохыг хэлнэ;
- (h) “нийтийн цахилгаан холбооны дамжуулах сүлжээ” гэх нэр томьёо нь тодорхой сүлжээний төгсгөлийн цэгүүд хооронд болон тэдгээрийн дунд цахилгаан холболтын боломжийг олгож байгаа нийтийн цахилгаан холбооны дэд бүтцийг хэлнэ;

- (i) “нийтийн цахилгаан холбооны дамжуулах үйлчилгээ” гэх нэр томъёо нь тухайн Тал нийтэд саадгүйгээр, эсхүл хүртээмжтэйгээр үзүүлэхийг шаарддаг аливаа цахилгаан холбооны үйлчилгээг хэлнэ. Тийм үйлчилгээнд, жишээлбэл, хэрэглэгчийн түгээсэн мэдээллийн агуулга, эсхүл хэлбэрийг ямар нэгэн байдлаар өөрчлөхгүйгээр хоёр буюу түүнээс дээш цэгийн хооронд дамжуулалт хийдэг энэхүү телеграф, телефон, телекс, эсхүл өгөгдөл дамжуулах зэрэг ажиллагаа орж болно;
- (j) “дахин худалдах” гэх нэр томъёо нь нийтийн цахилгаан холбооны дамжуулах сүлжээ, эсхүл үйлчилгээ үзүүлэгчийн үзүүлж буй үйлчилгээнд өртөг нэмж, эсхүл нэмэлгүйгээр, арилжааны зориулалтаар цааш нь дамжуулан худалдах, эсхүл түрээслэхийг хэлнэ;
- (k) “цахилгаан холбоо” гэх нэр томъёо нь аливаа цахилгаан соронзон аргаар дохио дамжуулах болон хүлээн авахыг хэлнэ;
- (l) “цахилгаан холбооны зохицуулах байгууллага” гэх нэр томъёо нь цахилгаан холбооны зохицуулалтын асуудал эрхэлсэн байгууллагыг хэлнэ;
- (m) “хэрэглэгчид” гэх нэр томъёо нь үйлчилгээ авагч болон үйлчилгээ үзүүлэгчийг хэлнэ.

3 дугаар зүйл Нэвтрэх ба ашиглах

1. Тал бүр нөгөө Талын аливаа үйлчилгээ үзүүлэгч бүрт цаг хугацаанд нь, ил тод, бодитой, үл ялгаварлах үндсэн дээр нийтийн цахилгаан холбооны дамжуулах сүлжээ, үйлчилгээ, тэдгээрийг хэрэглэх болон нэвтрэх боломжоор хангана. Энэхүү үүрэг энэ зүйлийн 2-оос 6 дахь хэсэгт хамаарна.

2. Тал бүр нь өөрийн холбооны хувийн шугамын түрээсийг оролцуулан, өөрийн нутаг дэвсгэрийн хүрээнд, эсхүл хилээрээ дамнуулан нийтийн цахилгаан холбооны дамжуулах сүлжээ, эсхүл үйлчилгээг нөгөө Талын үйлчилгээ үзүүлэгчдэд хэрэглэх болон нэвтрэх боломжийг хангах бөгөөд энэ зорилгоор 5 болон 6 дахь хэсгийн дагуу тийм үйлчилгээ эрхлэгчдэд дор дурдсаныг зөвшөөрнө:

- (a) сүлжээнд холбож болох, өөрийн үйлчилгээг хүргэхэд шаардлагатай төгсгөлийн байгууламж, эсхүл бусад төрлийн төхөөрөмжийг худалдан авах, эсхүл түрээслэх, холбох;
- (b) хувийн түрээсийн, эсхүл эзэмшиж буй холбооны шугамыг нийтийн цахилгаан холбооны дамжуулах сүлжээ болон үйлчилгээтэй, эсхүл бусад үйлчилгээ үзүүлэгчийн хувийн түрээсэлсэн, эсхүл эзэмшиж буй холбооны шугамд залгах;
- (c) цахилгаан холбооны дамжуулах сүлжээ, эсхүл үйлчилгээг олон нийтэд хүртээмжтэй байх боломжийг хангахад шаардлагатайгаас бусад тохиолдолд аливаа үйлчилгээг үзүүлэхэд өөрийн сонгосон үйлдлийн протоколыг ашиглах.

3. Тал бүр нь нөгөө Талын үйлчилгээ үзүүлэгчийг өөрийн нутаг дэвсгэрийн хүрээнд, эсхүл хилээрээ дамжуулан, үйлчилгээ үзүүлэгчийн корпорацийн доторх холбоог оролцуулан, Дэлхийн худалдааны байгууллагын аливаа гишүүний, эсхүл Талуудын мэдээллийн санд байгаа, эсхүл төхөөрөмжөөр унших боломжтой хэлбэрээр хадгалагдаж буй мэдээлэлд нэвтрэх зорилгоор нийтийн цахилгаан холбооны дамжуулах сүлжээ болон үйлчилгээг ашиглах боломжоор хангана.

4. 3 дахь хэсгийн заалтыг үл харгалзан, аль нэг Тал дараахь зорилгоор шаардлагатай арга хэмжээ авч болно:

- (a) мэдээллийн аюулгүй байдал болон нууцлалыг хангах;
- (b) нийтийн цахилгаан холбооны дамжуулах сүлжээ болон үйлчилгээний хэрэглэгчдийн хувийн мэдээллийг хамгаалах.

Эдгээр арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ зохиомол, эсхүл үндэслэлгүйгээр ялгаварлан гадуурхах байдал бий болгох, эсхүл үйлчилгээний худалдаанд нуугдмал хязгаарлалт тогтоох байдлаар ашиглахгүй байх нөхцөлийг хангана.

5. Тал бүр дор дурдсан зүйлд шаардлагатайгаас бусад тохиолдолд нийтийн цахилгаан холбооны дамжуулах сүлжээ, үйлчилгээг ашиглах болон нэвтрэх ямар нэгэн нөхцөлийг тулган хүлээлгэхгүй байх явдлыг хангана:

- (a) нийтийн цахилгаан холбооны дамжуулах сүлжээ болон үйлчилгээ, ялангуяа эдгээр сүлжээ, эсхүл үйлчилгээг олон түмэнд хүртээмжтэй болгох тэдгээрийн боломжийг бий болгох талаар үйлчилгээ үзүүлэгчийн хариуцлагыг баталгаатай болгох;

- (b) нийтийн цахилгаан холбооны дамжуулах сүлжээ болон үйлчилгээний техникийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах.

6. 5 дахь хэсэгт тогтоосон шалгуурыг хангасан тохиолдолд, нийтийн цахилгаан холбооны дамжуулах сүлжээ болон үйлчилгээнд нэвтрэх нөхцөл нь дор дурдсаныг агуулж болно:

- (a) дахин худалдах, эсхүл тийм үйлчилгээг хамтран ашиглах явдлыг хязгаарлах;
- (b) нийтийн цахилгаан холбооны дамжуулах сүлжээ болон үйлчилгээнд тодорхой заагдсан харилцан холболт хийхэд холболтын протокол зэрэг техникийн холболтыг ашиглахыг шаардах;
- (c) шаардлагатай тохиолдолд, нийтийн цахилгаан холбооны дамжуулах үйлчилгээний харилцан ажиллах чадамжийг хадгалахад тавих шаардлага болон энэхүү хавсралтын 13 дугаар зүйлд дэвшүүлсэн зорилтод хүрэхэд дэмжлэг үзүүлэх;
- (d) нийтийн цахилгаан холбооны дамжуулах сүлжээтэй холбох төгсгөлийн байгууламж, эсхүл бусад тоног төхөөрөмжийн загварын зөвшөөрөл болон эдгээр тоног төхөөрөмжийг тийм сүлжээнд холбохтой хамааралтай техникийн шаардлага;
- (e) хувийн түрээсийн, эсхүл эзэмшиж буй холбооны шугамыг нийтийн цахилгаан холбооны дамжуулах сүлжээ, эсхүл бусад үйлчилгээ үзүүлэгчийн түрээсийн, эсхүл эзэмшиж буй холбооны шугамд холбохыг хязгаарлах;
- (f) мэдэгдэл хийх, бүртгэх болон зөвшөөрөл олгох.

4 дүгээр зүйл

Өрсөлдөөнийг дэмжих хамгаалалт

1. Тал бүр голлох үйлчилгээ үзүүлэгчийг дангаар, эсхүл хамтран өрсөлдөөнийг хязгаарласан үйл ажиллагаа явуулах, эсхүл ийм үйлдлийг үргэлжлүүлэхээс хамгаалах зорилгоор зохих арга хэмжээг батлах буюу үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан өрсөлдөөнийг хязгаарласан үйл ажиллагаанд дараахь хамаарна. Тухайлбал:

- (a) өрсөлдөөнийг хязгаарлахад харилцан татаас олгох үйлдэл хийх;
- (b) өрсөлдөгчөөсөө олж авсан мэдээллийг өрсөлдөөний эсрэг үр дүнд хүрэх зорилгоор ашиглах;
- (c) нийтийн цахилгаан холбооны дамжуулах сүлжээ, эсхүл үйлчилгээг бусад үйлчилгээ үзүүлэгчдэд үндсэн байгууламжтай холбоотой техникийн мэдээлэл болон тэдгээрийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай арилжааны зохих мэдээллийг цаг тухайд нь өгөхгүй байх.

5 дугаар зүйл Дахин худалдах

Тал бүр өөрийн нутаг дэвсгэрт буй нийтийн цахилгаан холбооны дамжуулах сүлжээ, үйлчилгээ үзүүлэгчид нь нөгөө Талын нийтийн цахилгаан холбооны дамжуулах сүлжээ, эсхүл үйлчилгээ үзүүлэгчийн дамжуулан худалдах үйлчилгээнд үндэслэлгүй, эсхүл ялгавартай нөхцөл тавих буюу хязгаарлалт хийхгүй байх нөхцөлийг хангана.

6 дугаар зүйл Харилцан холболт

1. Тал бүр өөрийн хууль тогтоомжид заасан хүрээнд нэг Талын нутаг дэвсгэрт буй тэдгээрийн нийтийн цахилгаан холбооны дамжуулах сүлжээ, эсхүл үйлчилгээ үзүүлэгч нь нөгөө Талын нийтийн цахилгаан холбооны дамжуулах сүлжээ, эсхүл үйлчилгээ үзүүлэгчид харилцан холболт олгохыг хангана.

2. Тал бүр өөрийн нутаг дэвсгэрт нь байгаа үндсэн дэд бүтцийг хянаж буй голлох үйлчилгээ үзүүлэгчийг техникийн хувьд боломжтой сүлжээний цэгт харилцан холболт хийх нөхцөлийг хангана. Уг харилцан холболтыг дараахь нөхцөлөөр хангана:

- (a) үл ялгаварлах нөхцөл, болзол (техникийн стандарт, шаардлагыг оролцуулан) болон үнэ тариф;

- (b) дээр дурдсан голлох үйлчилгээ үзүүлэгчийн өөрийн ижил төрлийн үйлчилгээнд олгодгоос дутуугүй тааламжтай нөхцөлийг харилцан хамааралгүй үйлчилгээ үзүүлэгчийн, эсхүл түүний харъяа буюу бусад байгууллагын ижил төрлийн үйлчилгээнд олгох;
- (c) Харилцан холболтыг ил тод, бодит болон эдийн засгийн хувьд боломжтой, хангалттай нарийвчилсан өртөгт суурилсан үнэ болон нөхцөл, болзолор (техникийн стандарт, шаардлагыг оролцуулан) цаг тухайд нь хангаснаар нөгөө Талын цахилгаан холбооны дамжуулах сүлжээ, эсхүл үйлчилгээ үзүүлэгч нь тухайн үйлчилгээг үзүүлэхэд шаардагдахгүй сүлжээний бүрдэл, эсхүл байгууламжтай холбоотой төлбөр төлөх шаардлагагүй;
- (d) хүсэлтийн дагуу, хэрэглэгчдийн дийлэнх хэсэг холбогддог сүлжээний төгсгөлийн цэгээс бусад төгсгөлийн цэгт шаардлагатай нэмэлт байгууламжийг суурилуулах зардлыг тусгасан үнээр холболт хийх.

3. Тал бүр голлох үйлчилгээ үзүүлэгчтэй харилцан холболт хийх журмыг олон нийтэд нээлттэй байх явдлыг хангана.

4. Тал бүр өөрийн нутаг дэвсгэрт буй голлох үйлчилгээ үзүүлэгчийн харилцан холболтын тухай хэлэлцээр буюу харилцан холболтын жишиг саналыг олон нийтэд нээлттэй байх явдлыг хангана.

7 дугаар зүйл

Бие даасан зохицуулах байгууллага

1. Тал бүр өөрийн цахилгаан холбооны зохицуулах байгууллагыг цахилгаан холбооны аливаа үйлчилгээ үзүүлэгчээс бие даасан, хараат бус байх нөхцөлийг хангана.

2. Тал бүр өөрийн цахилгаан холбооны зохицуулах байгууллагын гаргасан шийдвэр, мөрдөх журам нь зах зээлд оролцогчдод алагчилалгүй байх явдлыг хангана.

8 дугаар зүйл

Бүх нийтийн үйлчилгээ

Тал бүр өөрийн хэрэгжүүлэх бүх нийтийн үйлчилгээгээр хүлээх үүргийг тодорхойлох эрхтэй. Тухайн үүргийг ил тод, үл ялгаварласан, өрсөлдөөний хувьд төвийг сахисан байдлаар хэрэгжүүлж, тухайн Талын тодорхойлсон бүх нийтийн үйлчилгээний төрөлд шаардлагагүй дарамт үзүүлэхгүй бол өрсөлдөөнийг хязгаарласан гэж үзэхгүй.

9 дүгээр зүйл

Тусгай зөвшөөрөл олгох шалгуурыг олон нийтэд нээлттэй болгох

1. Цахилгаан холбооны үйлчилгээ үзүүлэхэд тусгай зөвшөөрөл авах шаардлагатай тохиолдолд Талууд дараахь зүйлийг олон нийтэд нээлттэй болгоно:

- (a) тусгай зөвшөөрөл олгоход тавих бүх шаардлага, тусгай зөвшөөрөл авахаар гаргасан өргөдлийг шийдвэрлэх хугацаа;
- (b) тус тусын тусгай зөвшөөрөл бүрийн болзол, нөхцөл.

2. Тал бүр гаргасан шийдвэрийнхээ талаар өргөдөл гаргагчид хугацаа алдалгүй мэдэгдэнэ. Өргөдөлд татгалзсан, эсхүл тусгай зөвшөөрлийг цуцлах шийдвэр гаргасан тохиолдолд, өргөдөл гаргагчийн хүсэлтийн дагуу Тал бүр тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан, эсхүл тусгай зөвшөөрлийг цуцалсан талаар тайлбарыг өгнө.

10 дугаар зүйл

Хязгаарлагдмал нөөцийг хуваарилах, ашиглах

1. Тал бүр радио давтамж, дугаарлалт болон сувагчлалын техникийн нөхцөлийг оролцуулан цахилгаан холбоонд хамаарах ховор нөөцийг хуваарилах, ашиглах аливаа журмыг бодитой, цаг тухайд нь, ил тод, үл ялгаварлах байдлаар хэрэгжүүлнэ.

2. Тал бүр нь төрийн тусгай хэрэгцээнд хуваарилсан радио давтамжийн дэлгэрэнгүй мэдээллээс бусад радио давтамжийн хуваарилалтын өнөөгийн байдлыг нийтэд ил тод болгоно.

3. Давтамжийн зурвас хуваарилах, олгох ба давтамжийг зохицуулах талаар аль нэг Талын авч буй арга хэмжээг 7.5 дугаар зүйлтэй үл нийцэх арга хэмжээ гэж үзэхгүй. Түүнчлэн, Талууд энэхүү хэлэлцээрийн бусад заалт, ялангуяа 7.3 дугаар зүйлтэй нийцэхүйц нийтийн цахилгаан холбооны дамжуулах сүлжээ, эсхүл үйлчилгээ үзүүлэгчийн тоог хязгаарлахад нөлөөлөхүйц зурвас, давтамжийн зохицуулалтын бодлогыг бий болгох болон зурвасыг ашиглах эрхтэй. Энэхүү эрхэд өнөөгийн болон ирээдүйн хэрэгцээ, давтамжийн зурвасын хүртээмжтэй байдлыг харгалзан, давтамжийн зурвасыг хуваарилах чадамж орно.

11 дүгээр зүйл Ил тод байдал

Тал бүр нь олон нийтэд нээлттэй явуулж буй нийтийн цахилгаан холбооны дамжуулах сүлжээ, эсхүл үйлчилгээнд нэвтрэх, ашиглахтай холбоотой арга хэмжээг дараахь зүйлийг оролцуулан хангана:

- (a) тариф, үйлчилгээ үзүүлэх бусад нөхцөл;
- (b) техникийн холболтын үзүүлэлт;
- (c) тийнхүү нэвтрэх, ашиглах асуудлыг хөндсөн стандартыг боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, батлах үүрэг бүхий байгууллага;
- (d) нийтийн цахилгаан холбооны дамжуулах сүлжээний төгсгөлийн байгууламж, эсхүл бусад тоног төхөөрөмжийн холболтын нөхцөл;
- (e) хэрэв шаардлагатай бол мэдэгдэл хийх, бүртгэх, эсхүл тусгай зөвшөөрөл олгоход тавих шаардлага.

12 дугаар зүйл Цахилгаан холбооны талаарх маргааныг шийдвэрлэх

1. Тал бүр өөрийн хууль тогтоомжийн хүрээнд нөгөө Талын нийтийн цахилгаан холбооны дамжуулах сүлжээ, эсхүл үйлчилгээ үзүүлэгч цахилгаан холбооны зохицуулах байгууллага, эсхүл маргаан шийдвэрлэх байгууллагад цаг тухайд нь хандан, маргаан шийдвэрлүүлэх явдлыг хангана.

2. Тал бүр нь өөрийн хууль тогтоомжийн хүрээнд холбогдох цахилгаан холбооны зохицуулах байгууллагын үйлдэл, эсхүл шийдвэрийн улмаас хохирсон нийтийн цахилгаан холбооны дамжуулах сүлжээ, эсхүл аливаа үйлчилгээ үзүүлэгч нь холбогдох тэрхүү байгууллагыг үйлдэл, эсхүл шийдвэрээ дахин хянаж үзэхийг хүсэх өргөдөл гаргах нөхцөлийг хангана. Уг өргөдлийг зохих байгууллагаас тухайн үйлдэл, эсхүл шийдвэрийг цуцалсан, эсхүл эргүүлэн татсанаас бусад тохиолдолд тухайн байгууллагын гаргасан үйлдэл, эсхүл шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл болохыг аль ч тал зөвшөөрөхгүй.

3. Талууд өөрийн хууль тогтоомжийн хүрээнд цахилгаан холбооны зохицуулах байгууллагын эцсийн тогтоол, эсхүл шийдвэрт гомдолтой байгаа нийтийн цахилгаан холбооны дамжуулах аливаа сүлжээ, эсхүл үйлчилгээ үзүүлэгч тухайн тогтоол, эсхүл шийдвэрийг бие даасан шүүхийн байгууллагаар хянуулах өргөдөл гаргах нөхцөлийг хангана. Уг асуудлыг хянуулахыг шүүхийн зохих байгууллагаас тухайн үйлдэл, эсхүл шийдвэрийг түдгэлзүүлсэн, цуцалсан, эсхүл эргүүлэн татсанаас бусад тохиолдолд аль ч Тал тухайн цахилгаан холбооны зохицуулах байгууллагын гаргасан үйлдэл, эсхүл шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл болохыг зөвшөөрөхгүй.

13 дугаар зүйл

Олон улсын байгууллагатай харилцах

Талууд цахилгаан холбооны сүлжээ, үйлчилгээний нийтлэг зохицол, харилцан үйлчлэлийг хангахад олон улсын стандарт чухал гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд Олон улсын цахилгаан холбооны байгууллага, Олон улсын стандартын байгууллага зэрэг олон улсын холбогдох байгууллагын ажлын журмаар тэдгээр стандартыг түгээн дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.